



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/493

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн мэдээний дэлгэрэнгүй жагсаалт”-ыг хоёрдугаар, “Мэдээллийн сангаас гаргах тайлангийн маягт”-ыг гуравдугаар, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэршлийн жагсаалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг шинэчлэн бүрдүүлж, сангийн үйл ажиллагааны тогтмол байдлыг хангаж ажиллахыг Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлэг, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажилладаг бусад төрийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081606

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 06 -ны өдрийн
А/493 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан (цаашид “мэдээллийн сан” гэх) -г бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, тайлагнах, ашиглах, хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Мэдээллийн санд Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлэг, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажилладаг бусад төрийн байгууллага (цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх) хамрагдана.

1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага тодорхойлох, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах, нэгдсэн бодлого төлөвлөлтөөр зохицуулах, статистик тоо мэдээ гаргах, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд ашиглана.

1.4 Мэдээллийн сангийн програм хангамж нь эмийн бүртгэлийн мэдээллийн сан /Licemed/ болон Эмийн аюулгүй байдлын системийн програм хангамжтай холбогдон ажиллана.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1 “эмнэлгийн тоног төхөөрөмж” гэж өвчин, эмгэг, гэмтэл согогийг оношлох, эмчлэх, хянах, нөхөн сэргээхэд дангаар болон дагалдах хэрэгсэлтэй хослуулан хэрэглэх, мэргэжлийн үйл ажиллагаа шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг;

2.1.2 “эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил ангилал, хангамж, ашиглалт, чанар аюулгүй байдал, засвар үйлчилгээ, хүний нөөц болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн талаарх цогц мэдээллийг;

2.1.3 “мэдээллийн технологийн тоног төхөөрөмж” гэж компьютер болон програм хангамжийг хэрэглэн мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон хүлээн авахад шаардлагатай тоног төхөөрөмжийг;

2.1.4 “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэршлийн систем /Universal Medical Device Nomenclature system/” гэж олон улсын яаралтай тусламжийн судалгааны хүрээлэн /Emergency Care Research Institute/ –ээс гаргасан эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр, товч тайлбар, бүртгэлийн давтагдашгүй дугаар бүхий стандартчилагдсан жагсаалтыг;

Гурав. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1 Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл нь олон улсын эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршлийн систем /Universal Medical Device Nomenclature system/ -ийн дагуу Монгол - Англи нэршилтэй байх ба системийн өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хийж байна.

3.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалт, тооцоо судалгаа, статистик тоо мэдээ, тайлан гаргахдаа энэхүү нэршлийн дагуу гаргана.

3.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан нь байнгын тогтмол үйл ажиллагаатай байна.

3.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан нь эрүүл мэндийн салбарын хөрөнгийн төлөвлөлтийн програм хангамжид суурилсан байх ба энэхүү програм хангамж нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд харьяалагдана.

3.5 Эрүүл мэндийн байгууллага нь “Эрүүл мэндийн салбарын хөрөнгийн төлөвлөлт” -ийн програм хангамжид нэвтрэх эрхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанаас авна.

Дөрөв. Мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, тайлагнах

4.1 Мэдээллийн сан нь энэхүү тушаалын 2 дугаар хавсралтад заасан мэдээний бүтэцтэй байна.

4.2 Мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг Эрүүл мэндийн хөгжлийн төв эрхэлнэ.

4.3 Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

4.4 Эрүүл мэндийн байгууллага нь мэдээллийн санг бүрдүүлэхэд дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

4.4.1 Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын тушаалаар мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлэх, тайлагнах үүрэг бүхий санхүүгийн мэргэжилтэнг, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалт, мэдээллийн сангийн хэвийн, тогтмол үйл ажиллагааг ханган ажиллах үүрэг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн болон мэдээлэл технологийн инженер эсвэл холбогдох мэргэжилтэнг томилон ажиллуулах;

4.4.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавиж, тайлан мэдээг нэгтгэж ажиллах;

4.4.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалттай холбоотой мэдээллийг цахим програмын өгөгдлийн дагуу баяжуулах;

4.4.4 Эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах;

4.4.5 Мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцах;

4.5 Мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлэхдээ эмнэлгийн болон мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн техникийн бичиг баримт болон холбогдох бусад материалд үндэслэн бүрдүүлж хөтлөх;

4.6 Эрүүл мэндийн байгууллага нь жил бүрийн 5 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 30-ний өдрүүдэд эмнэлгийн болон мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сангийн тайланг гаргаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлэх;

4.7 Мэдээллийн сангийн мэдээллийг төвлөрүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн хөгжлийн төв нь мэдээллийн санг бүрдүүлж хөтлөхөд дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

4.7.1 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг хүлээн авч, мэдээллийг нэгтгэх;

4.7.2 Мэдээллийн сангийн мэдээллийг интернетийн орчинд ашиглах боломжтой сангийн хэлбэрээр олон нийтэд түгээх, хэрэглэгчдийн мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.7.3 Мэдээллийн санд орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийж, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг холбоотой мэдээллээр хангах;

4.7.4 Мэдээллийн сан бүрдүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах, програм хангамжийг шинэчлэх санал гаргах;

4.7.5 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, програм хангамжийн найдвартай ажиллагааг хангах, өдөр тутмын хэвийн ажиллагааг хянаж ажиллах мэргэжилтэнтэй байх;

4.8 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь жил бүрийн 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-нд эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн тайланг гаргаж, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх;

Тав. Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалах

5.1 Мэдээллийн сангийн мэдээллийг дараах байдлаар ашиглана. Үүнд:

5.1.1 Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хангамж, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалтын талаар тайлан мэдээ гаргах, мэдээлэл хийх;

5.1.2 Эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, хүний нөөц, сэлбэг хэрэгслийн хэрэгцээний үнэлгээ хийх зарим суурь мэдээлэл бэлтгэх;

5.1.3 Эрүүл мэндийн байгууллага байгуулах, барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд шаардлагатай мэдээлэл бэлтгэх;

5.1.4 Эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн талаар бусад салбар байгууллагад лавлагааны мэдээлэл бэлтгэх;

5.1.5 Олон нийтийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл бэлтгэх, түгээх;

5.1.6 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

5.2 Мэдээллийн сангийн мэдээллийг ашигласан тохиолдолд эх сурвалжийг заавал дурдсан байна.

5.3 Мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлж хөтлөх, төвлөрүүлэх байгууллага нь шаардлагатай тохиолдолд сангийн ашиглалтын бүртгэл хөтөлж, тайланг гаргана.

5.4 Мэдээллийн сангийн мэдээллийг дараах байдлаар хадгална. Үүнд:

5.4.1 Мэдээллийн сангийн архивлах ажиллагааг өдөр бүр хийж, түүнд хяналт тавьдаг байх;

5.4.3 Архивын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу архивын нөхөн бүрдүүлэлт хийх;

5.4.4 Мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх бөгөөд цахим болон цаасан хэлбэрээр хадгалах;

5.5 Мэдээллийн санд дараах үйлдлүүд хийхийг хориглоно. Үүнд:

5.5.1 Мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг өөрчлөх, устгах, зөвшөөрөлгүйгээр хуулбарлах;

5.5.2 Мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх;

5.5.3 Мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл ажиллагааг санаатай болон санамсаргүй байдлаар алдагдуулах, эвдэх, гэмтээх;

5.5.4 Мэдээллийн санд хортой код тараах;

5.5.5 Мэдээллийн санд агуулагдаж байгаа байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

5.5.6 Мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах;

5.5.7 Мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах;


5.5.8 Мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхээ ашиглан сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах;

Зургаа. Хариуцлага

6.1 Энэхүү журмыг зөрчсөн эрүүл мэндийн байгууллага болон хариуцсан албан тушаалтанд Эрүүл мэндийн тухай, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 06 -ны өдрийн
А/493 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЭДЭЭНИЙ ЖАГСААЛТ

НЭГ. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

1. Бүртгэл
 - 1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмж
 - 1.2 Эмнэлгийн багаж хэрэгсэл
 - 1.3 Түргэн тусламжийн тэрэг
 - 1.4 Элэгдэл
2. Шалгалт тохируулга/баталгаажуулалт
 - 2.1 Тохиргоо
 - 2.2 Шалгалт баталгаажуулалт
 - 2.3 Хяналт
3. Техник ашиглалтын паспорт
 - 3.1 Эд хариуцагч
 - 3.2 Эргэлт үйлчилгээ
 - 3.3 Техникийн үзлэг
 - 3.4 Засвар үйлчилгээ
 - 3.5 Техникийн ашиглалт
 - 3.6 Сул зогсолт
 - 3.7 Гэмтсэн төхөөрөмж
 - 3.8 Актлагдсан төхөөрөмж

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

1. Компьютер
 - 2.1 Ширээний компьютер
 - 2.2 Зөөврийн компьютер
2. Сервер
 - 2.1 Сервер төхөөрөмж
 - 2.2 Серверийн өрөө
3. Хэвлэх төхөөрөмж
 - 3.1 Хувилагч / Канон
 - 3.2 Хэвлэгч /Принтер
 - 3.3 Скайнер
4. Бусад
 - 4.1 Сүлжээний төхөөрөмж
 - 4.2 Програм хангамж
 - 4.3 Телемедицины тоног төхөөрөмж
 - 4.4 Интернетийн мэдээлэл
 - 4.5 Мэдээлэл технологийн багаж хэрэгсэл

ГУРАВ. БАЙГУУЛЛАГА

1. Байгууллага

- 1.1 Эрүүл мэндийн байгууллага
- 1.2 Ханган нийлүүлэгч байгууллага
- 1.3 Ажилтан

2. Лавлах

- 2.1 Эрүүл мэндийн байгууллагын ангилал
- 2.2 Тасаг нэгж
- 2.3 Инженер
- 2.4 Төлөөлөгч

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 06 -ны өдрийн
А/493 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

Маягт № 1

1. НЭН ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
Байгууллагын нэр:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1				
2				

Маягт № 2

2. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУГАЦААТАЙ СЭЛБЭГ
ХЭРЭГСЭЛ

Байгууллагын нэр:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк, төрөл	Сэлбэг, хэрэгслийн нэр	Сэлбэг солих хугацаа	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1							
2							

Маягт № 3

3. ӨРТӨГ ӨНДӨРТЭЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СЭЛБЭГ ХЭРЭГСЛҮҮД,
БАТАЛГААТ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын нэр:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Засвар үйлчилгээний нэр	Засвар үйлчилгээний хугацаа	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1						
2						

4. ГЭМТЭЛТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Байгууллагын нэр:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Гэмтлийн код	Гэмтсэн огноо	Тайлбар	Зардлын төсөв	Ханган нийлүүлэгч байгууллага	Засагд сан эсэх
1							
2							

5. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шалгалт тохируулгад хамрагдах ёстой нийт эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо	Шалгалт тохируулгад хамрагдах ёстой эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо														
			Амьсгалын аппарат	Дефибриллятор	Дуслын автомат шахуурга	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Компьютер томографийн аппарат	Наркозын аппарат	Нярайн дулаацуулах ширээ	Нярайн инкубатор	Өвчтөний хяналтын монитор	Рентген аппарат	Тариурын автомат шахуурга	Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч	Хэт авиан оношилгооны аппарат	Цахилгаан мэс заслын аппарат	
1																	
2																	

6. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шалгалт тохируулгад тэнцсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо	Шалгалт тохируулгад тэнцээгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо	Хэвийн ажиллагаанд оруулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо			Хэвийн ажиллагаанд ороогүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо		
				Засвар тохируулга хийсэн	Засвар үйлчилгээ хийсэн	Дахин шалгалт тохируулгад хамрагдсан	Сэлбэг хэрэгслэл хүлээж байгаа	Ашиглахыг хориглож актлах хүсэлтэй байгаа	Бусад
1									
2									


7. АШИГЛАГДАЖ БУЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
Байгууллагын нэр:

№	Тоног төхөөрөмжийн ерөнхий нэршил	марк модель	үйлдвэрийн дугаар	үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгчийн нэр	үйлдвэрлэсэн он	ашигдалтад орсон он	нэг бүрийн үнэ /төгрөг/	эх үүсвэр /ханган нийлүүлэгч
1								
2								

8.ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮНИЙ НӨӨЦ

№	Байгууллагын нэр	Овог	Нэр	Мэргэжил	Албан тушаал	Ажилласан жил	Утас
1							

2017 оны 12-р сарын 06-ны өдрийн
А/499 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ОЛОН УЛСЫН НЭРШЛИЙН ЖАГСААЛТ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ			
1.1 Дотор, мэдрэл судлалын тоног төхөөрөмж			
1.	13-106	Даралтны аппарат	Sphygmomanometers
2.	16-157	Даралтын аппарат, электрон	Sphygmomanometers, Electronic
3.	17-148	Пульсоксиметр	Oximeters, Pulse
4.	11-407	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Electrocardiographs
5.	11-413	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, нэг сувагт	Electrocardiographs, Single-Channel
6.	11-411	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, олон сувагт	Electrocardiographs, Multichannel
7.	17-423	Амьсгалын аппарат, зөөврийн/гэрийн	Ventilators, Portable/Home Care
8.	20-169	Монитор, Өвчтөний орны дэргэдэх	Monitors, Bedside
9.	20-179	Монитор, Өвчтөний хяналтын төв	Monitors, Central Station
10.	17-156	Хөргөгч, Эмзүй	Refrigerators, Pharmacy
11.	18-455	Жинлүүр, Өвчтөний	Scales, Patient
12.	23-996	Хэт авиан оношилгооны аппарат, Элэгний хатуурал	Scanning Systems, Ultrasonic, Abdominal, Liver Stiffness
13.	20-378	Хэт авиан оношилгооны аппарат, Дотор эрхтний дуран	Scanning Systems, Ultrasonic, Endoscopic
14.	17-746	Хэт авиан оношилгооны аппарат, Судсан дотор	Scanning Systems, Ultrasonic, Intravascular
15.	13-674	Спирометр	Spirometers
16.	13-958	Ор, Үзлэг, Эмчилгээний	Tables, Examination/Treatment
17.	17-570	Дулаацуулагч аппарат, Өвчтөний	Warming Units, Patient
18.	12-068	Дулаацуулах/ Хөргөх аппарат, Өвчтөний	Warming/Cooling Units, Patient
19.	10-208	Сорох аппарат	Aspirators
20.	11-218	Гемодиализийн аппарат	Hemodialysis Units
1.2 Хүүхэд, өсвөр үе судлалын тоног төхөөрөмж			
21.	12-815	Нүдний дуран, /Офтальмоскоп/	Ophthalmoscopes
22.	25-473	Судас тодруулагч, Хэт улаан туяаны	Vein Finders, Infrared Light
23.	10-362	Ор, Хүүхдийн Хөдөлгөөнгүй, Тулгууртай,	Beds, Fixed, Cradle, Pediatric
24.	18-392	Ор, Хүүхдийн Механик, Тулгууртай,	Beds, Mechanical, Cradle, Pediatric
1.3 Эх барих, эмэгтэйчүүд, нярай судлалын тоног төхөөрөмж			
25.	10-214	Сорох аппарат, Амьсгалын замын, Хамрын, Нярайн	Aspirators, Airway, Nasal, Infant
26.	10-222	Сорох аппарат, Умайн	Aspirators, Uterine
27.	12-113	Инкубатор, Нярайн	Incubators, Infant
28.	12-610	Монитор, Өвчтөний орны дэргэдэх, Ургийн байрлалын	Monitors, Bedside, Fetal
29.	13-462	Жинлүүр, Нярай хүүхэд	Scales, Infant
30.	15-109	Билирубин хэмжигч	Bilirubinometers

31.	15-657	Хэт авиан оношилгооны аппарат, Эх барих/ Эмэгтэйчүүдийн өвчин судлал	Scanning Systems, Ultrasonic, Obstetric/Gynecologic
32.	15-732	Ор, Цахилгаан, Төрөх	Beds, Electric, Birthing
33.	16-168	Ор, Хөдөлгөөнгүй, үелсэн давхарга Эмчилгээ, Нярайн /усан эмчилгээ/	Beds, Fixed, Flotation Therapy, Neonatal
34.	18-393	Ор, Механик, Нярайн	Beds, Mechanical, Neonatal
35.	18-397	Ор, Хөдөлгөөнгүй, Нярайн	Beds, Fixed, Neonatal
36.	20-181	Монитор, Телеметр, Умайн үйл ажиллагаа	Monitors, telemetr, Uterine Activity
37.	33-256	Гэрэл, Үзлэг, Хананд суурилуулсан	Lights, Examination, Wall-Mounted
1.4 Мэс засал судлалын тоног төхөөрөмж			
38.	12-282	Гэрэл, Мэс заслын	Lights, Surgical
39.	33-268	Гэрэл, Мэс заслын, Таазанд суурилуулсан	Lights, Surgical, Ceiling-Mounted
40.	33-265	Гэрэл, Мэс заслын, Бие даасан	Lights, Surgical, Stand-Alone
41.	33-262	Гэрэл, Мэс заслын, Хананд суурилуулсан	Lights, Surgical, Wall Mounted
42.	12-539	Микроскоп, Гэрэл, Мэс заслын	Microscopes, Light, Operating
43.	18-840	Бичил долгионы Мэс заслын аппарат	Microwave Surgical Units
44.	12-586	Монитор, Өвчтөний орны дэргэдэх, Цусны хийн	Monitors, Bedside, Blood Gas
45.	27-480	Монитор, Физиологийн, Мэдрэл, Булчингийн Цахилгаан бичлэг, Мэс заслын үеийн	Monitors, Physiologic, Neurology, Electromyographic, Intraoperative
46.	18-586	Азотын исэл хүргэх аппарат	Nitric Oxide Delivery Units
47.	13-961	Ор, Мэс заслын	Tables, Operating
48.	13-963	Ширээ, Эргэдэг тавцантай	Tables, Overbed
49.	18-049	Хэт авианы Мэс заслын аппарат	Ultrasound Surgical Units
50.	17-690	Бөөр шээс дамжуулах замын дуран	Ureterorenoscopes
51.	10-134	Унтуулгын аппарат	Anesthesia Units
52.	17-842	Унтуулгын аппарат, Шүдний	Anesthesia Units, Dental
53.	10-198	Үений дуран	Arthroscopes
54.	10-217	Сорох аппарат, Мэс заслын	Aspirators, Surgical
55.	18-051	Хөлдөөж мэдээ алдуулах Мэс заслын аппарат	Cryosurgical Units
56.	11-079	Савны амсрын дуран	Culdoscopes
57.	11-112	Давсагны дуран	Cystoscopes
58.	11-114	Давсаг сүвний дуран	Cystourethrosopes
59.	11-490	Цахилгаан Мэс заслын аппарат	Electrosurgical Units
60.	18-230	Цахилгаан Мэс заслын аппарат, 2 туйлт	Electrosurgical Units, Bipolar
61.	18-229	Цахилгаан Мэс заслын аппарат, 1 туйлт	Electrosurgical Units, Monopolar
62.	18-231	Цахилгаан Мэс заслын аппарат, 1 туйлт/2 туйлт	Electrosurgical Units, Monopolar/Bipolar
63.	18-232	Цахилгаан Мэс заслын аппарат, 1 туйлт/2 туйлт, Аргоны-Сайжруулсан Бүлэгнэлт	Electrosurgical Units, Monopolar/Bipolar, Argon-Enhanced Coagulation
64.	12-081	Савны дуран	Hysteroscopes
65.	12-144	Хийлэгч	Insufflators
66.	23-523	Хийлэгч, Дурангийн	Insufflators, Endoscopic
67.	12-291	Хэвлийн дуран	Laparoscopes
1.5 Гэмтэл согог судлалын тоног төхөөрөмж			
68.	10-360	Ор, Хөдөлгөөнгүй, Согог судлалын	Beds, Fixed, Orthopedic
69.	12-690	Нугасны дуран	Myeloscopes
70.	15-129	Нягт хэмжүүр	Densitometers
71.	17-152	Нягт хэмжүүр, Ясны	Densitometers, Bone

1.6 Шүд, эрүү нүүр судлалын тоног төхөөрөмж			
72.	10-212	Сорох аппарат, Шүдний	Aspirators, Dental
73.	12-276	Гэрэл, Үзлэг	Lights, Examination
74.	12-352	Гэрэл, Үзлэг, Шүдний/Аман дотор	Lights, Examination, Dental/ Intraoral
75.	13-269	Радиографик аппарат, Шүд	Radiographic Units, Dental
76.	15-866	Гэрэл, Үзлэг, Таазанд суурилуулсан	Lights, Examination, Ceiling- Mounted
77.	15-939	Рентген зураг угаагч, Автомат, Шүдний	X-Ray Film Processors, Automatic, Dental
78.	16-353	Акрилийн Эмчилгээний аппарат, Шүдний	Acrylic Curing Units, Dental
79.	17-796	Цутгамал Зуух, Шүдний	Casting Furnaces, Dental
80.	18-597	Шүдний Агаарыг Цэвэрлэх аппарат	Dental Air Abrasion Units
81.	23-492	Ваксерс, Шүдний Лаборатори	Waxers, Dental Laboratory
82.	27-898	Шүдний Загвар Тайрах суурь машин	Dental Model Trimmers
83.	27-899	Дулааны хуванцар үүсгэх аппарат, Вакуум, Шүдний лаборатори	Thermoplastic Forming Units, Vacuum, Dental Laboratory
1.7 Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ судлалын тоног төхөөрөмж			
84.	10-447	Дулаацуулагч аппарат, Цус/Судсаар Шингэн шахахад/	Warming Units, Blood/Intravenous Solution
85.	11-134	Дефибриллятор, Гаднах, Гар ажиллагаатай	Defibrillators, External, Manual
86.	12-873	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	Oxygen Concentrators
87.	13-059	Амьсгалын уушгины багтаамж шалгагч, Бие	Plethysmographs, Body
88.	14-386	Витректоми аппарат	Vitrectomy Units
89.	16-495	Дуслын автомат шахуурга	Infusion Pumps
90.	17-116	Дефибриллятор, Гаднах, Автоматажсан	Defibrillators, External, Automated
91.	18-143	Хэт авиан оношилгооны аппарат, Зөөврийн	Scanning Systems, Ultrasonic, Portable
92.	18-345	Капногарфи	Capnographs
93.	18-499	Дефибриллятор, Гаднах	Defibrillators, External
94.	18-863	Амьсгалын замын цэвэрлэгээний аппарат	Airway Clearance Units
95.	20-728	Капнометр	Capnometers
96.	25-119	Бичил тарилгын аппарат	Microinjectors
97.	27-657	Сорох аппарат, Амьсгалын замын	Aspirators, Airway
98.	29-721	Бичил тарилгын систем	Microinjection Systems
1.8 Оношилгоо, шинжилгээний тоног төхөөрөмж			
1.8.1 Дуран оношилгооны тоног төхөөрөмж			
99.	10-491	Уушгины уян дуран	Bronchoscopes
100.	11-856	Ходоодны уян дуран	Gastrosopes
101.	11-359	Арван хоёр нугалаа гэдэсний дуран	Duodenoscopes
102.	10-950	Бүдүүн гэдэсний дуран	Colonoscopes
103.	10-156	Шулуун гэдэсний дуран	Anoscopes
104.	10-831	Цэсний гол сувгийн дуран	Choledochoscopes
105.	11-526	Тархины дуран	Encephaloscopes
106.	11-603	Улаан хоолойн дуран	Esophagoscopes
107.	13-011	Залгиур хоолойн дуран	Pharyngoscopes
108.	20-488	Шүлсний булчирхайн дуран	Sialoscopes
109.	14-047	Цээжний дуран	Thorascopes
110.	14-289	Шээлүүрийн дуран	Urethrosopes

1.8.2 Рентген оношилгооны тоног төхөөрөмж			
111.	18-439	Компьютер томографи	Radiographic/Tomographic Systems
112.	13-267	Рентген аппарат /суурин/	Radiographic Units
113.	13-272	Рентген аппарат /зөөврийн/	Radiographic Units, Mobile
114.	18-430	Дижитал рентген харалтын аппарат	Radiographic Systems, Digital
115.	15-952	Флюорографийн аппарат	Radiographic/Fluoroscopic Units
116.	16-561	Рентген зураг хувиргагч	X-Ray Film Changers
1.8.3 Хэт авиан оношилгооны тоног төхөөрөмж			
117.	17-422	Зүрхний хэт авиан оношилгооны аппарат	Scanning Systems, Ultrasonic, Cardiac
ХОЁРДУГААР ХЭСЭГ. БУСАД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ			
2.1 Насжилт, настан судлалын тоног төхөөрөмж			
118.	18-464	Жинлүүр, Клиникийн	Scales, Clinical
2.2 Арьс харшил судлалын тоног төхөөрөмж			
119.	17-719	Микроскоп, Гэрэл, Үзлэг	Microscopes, Light, Examination
120.	15-165	Фотометр	Photometers
121.	23-917	Фототерафи аппарат, Хэт улаан	Phototherapy Units, Infrared
122.	23-544	Фототерафи аппарат, Хэт улаан/Лазер гэрэл	Phototherapy Units, Infrared, Pulse Lamp/Laser
123.	11-177	Арьсны гажгийг дарах аппарат	Dermabrasion Units
124.	18-193	Арьсны дуран	Dermoscopes
125.	18-858	Арьсны лазер гэрэл	Lasers, Diode, Dermatologic
2.3 Нүд судлалын тоног төхөөрөмж			
126.	14-067	Нүдний Тонограф	Ophthalmic Tonographs
127.	16-809	Нүдний Тонометр	Ophthalmic Tonometers
128.	12-811	Офтальмометр	Ophthalmometers
129.	23-679	Нүдний угийн дуран/Торлог бүрхүүлийн дуран	Ophthalmoscope/Retinoscopes
130.	18-190	Нүдний дуран, Лазер	Ophthalmoscopes, Scanning Laser
131.	13-313	Рефракторууд, Нүд	Refractors, Ophthalmic
132.	11-389	Хэт авиан оношилгооны аппарат, Нүдний	Scanning Systems, Ultrasonic, Ophthalmic
133.	15-794	Нүдний цагаан хальсыг хэмжих төхөөрөмж	Scleral Buckling Devices
134.	15-083	Спектрофотометр, Хэт ягаан туяаны/Харааны	Spectrophotometers, Ultraviolet/Visible
135.	15-084	Спектрофотометр, Харааны	Spectrophotometers, Visible
136.	13-970	Харааны сэрэл (хурд) хэмжүүр	Tachistoscopes
137.	24-553	Гажиг хэмжигч /Нүд/	Aberrometers
138.	16-342	Харалган оношлох дуран	Anomaloscopes
139.	10-964	Харааны талбай хэмжигч	Campimeters
140.	12-326	Линзометр	Lensometers
141.	24-555	Линзометр, Автомат	Lensometers, Automated
142.	24-554	Линзометр, Гар ажиллагаатай	Lensometers, Manual
2.4 Чих, хамар, хоолой судлалын тоног төхөөрөмж			
143.	10-228	Сонсголын бичлэгийн аппарат	Audiometers
144.	11-585	Чих/Хамар/Хоолойн аппарат	Эмчилгээний Ear/Nose/Throat Treatment Units
145.	12-709	Хамар-залгиур хоолойн дуран	Nasopharyngoscopes
146.	12-710	Хамрын дуран	Nasoscopes
147.	17-495	Цахилгаан сонсгол бичлэгийн аппарат	Electrocochleographs

2.5 Сэргээн засал судлалын тоног төхөөрөмж			
148.	10-538	Хэт ягаан туяаны аппарат /УФО/	Cabinets, Treatment, Ultraviolet
149.	12-712	Утлагын аппарат	Nebulizers
150.	12-719	Утлагын аппарат, Хэт авиан	Nebulizers, Ultrasonic
151.	12-956	Тосон ванн	Baths, Paraffin, Physical Therapy
2.6 Эмгэг судлалын тоног төхөөрөмж			
152.	13-953	Цогцост задлан хийх ширээ	Tables, Autopsy
153.	17-136	Задлан шинжилгээний ширээ	Tables, Dissecting
154.	15-156	Микроскоп	Microscopes, Light, Laboratory
155.	15-157	Микротом, Криостат	Microtomes, Cryostat
156.	15-158	Микротом, Эргэлдэгч	Microtomes, Rotary
157.	15-160	Микротом, Ультра	Microtomes, Ultra
158.	15-190	Эд эсийг боловсруулах процессор	Tissue Processors
159.	17-157	Лабораторийн хөргөгч	Refrigerators, Laboratory
160.	15-145	Лабораторийн хөлдөөгч	Freezers, Laboratory
161.	28-473	Будагч аппарат	Microarray Washer/Stainers
162.	24-138	Сорох шүүгээ	Laboratory Hoods
163.	20-616	Хадгалах шүүгээ, Лаборатори	Cabinets, Storage, Laboratory
164.	13-316	Цогцос хадгалах хөргөгч	Refrigerators, Morgue
ГУРАВ. ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ			
3.1 Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл			
165.	22-036	Хөлдөөгч, цусны	Freezers, Blood Bank
166.	10-971	Шахагч	Compressors
167.	23-134	Аферезийн аппарат, цусны донор	Apheresis Units, Blood Donor
168.	15-552	Бүлэгнэлтийн анализатор	Analyzers, Laboratory, Hematology, Coagulation
169.	10-780	Ширээний центрифуг	Centrifuges, Tabletop
170.	15-116	Суурин центрифуг	Centrifuges, Floor
3.2 Инженер техник, засвар үйлчилгээ			
171.	11-381	Симулятор, Зүрхний, Зүрхний Цахилгаан бичлэг	Simulators, Cardiac, Electrocardiography
172.	18-057	Симулятор, Тархины Цахилгаан бичлэг	Simulators, Electroencephalographic
173.	18-106	Симулятор, Инвазив Цусны даралт	Simulators, Invasive Blood Pressure
174.	18-107	Симулятор, Инвазив бус Цусны даралт	Simulators, Noninvasive Blood Pressure
175.	13-341	Симулятор, Амьсгал	Simulators, Respiration
176.	15-061	Симулятор, Температур	Simulators, Temperature
3.3 Ариутгал, халдваргүйтгэл, хог хаягдал			
177.	13-746	Автоклав, уураар ариутгагч аппарат	Sterilizing Units, Steam
178.	14-435	Ус цэвэржүүлэх систем, <u>ионоос ангижруулах</u>	Water Purification Systems, Deionization
179.	13-748	Ариутгагч аппарат, нам даралтын ариутгагч /дезикамер/	Sterilizing Units, Germicidal Vapor
3.4 Угаалга, цэвэрлэгээ			
180.	14-413	Угаалгын машин/ угааж ариутгах аппарат	Washer/Sterilizing Units
181.	21-090	Бул индүү	Laundry Presses